



## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг:  
enkzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл

Утас: 260512

Цахим хаяг:  
odgerell@audit.gov.mn

Ж.Батсайхан

Утас: 261628

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IY байр  
Бага тойруу -3  
Улаанбаатар-46  
Монгол улс

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2014 оны 4 дүгээр сар

### Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

#### Агуулга

Оршил  
Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ  
Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан  
шийдлүүд  
Залруулаагүй алдаа  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн  
тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан

## Оршил

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг Эрүүл мэндийн яамны удирдлагад танилцуулж байна.

Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд эрүүл мэндийн салбарын нийт 118 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх хуулийн хугацаанд өмнөх шатанд хийсэн аудитын дүнг нэгтгэж, дүн шинжилгээ хийхээс гадна аудит хийгдээгүй зарим төсвийн шууд захирагчийн санхүүгийн зарим үйл ажиллагаанд түүвэр сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэв.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, объект дээрх үе шат, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ

Бид үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг аудитын горимын дагуу дахин хянасан.

Аудитын явцад Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд үйл ажиллагаандаа холбогдох стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсөвт байгууллагад мөрдөх УСНББОУС-ийн бодлого, заавар, журмыг баримталж ажилласан байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт – шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар Эрүүл мэндийн салбарын 2013 оны үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлжээ.

Тус газар үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө удирдамжийг Эрүүл мэндийн сайдаар батлуулан ажилласан бөгөөд бодлогын хэрэгжилтийн ерөнхий үнэлгээ 78,6 хувьтай гарсан байна.

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	Үр дүнгийн үнэлгээ		
		Хувь	Оноо	
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	77.1	3.9
		2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	74.0	3.7
		3. Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт	80.1	4.0
		4. Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	89.3	4.5
		5. УИХ, Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	84.0	4.2
		6. Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт	84.1	4.2
<i>Үнэлгээний дундаж оноо</i>		<i>Хувь 81.5, Оноо 4.1</i>		
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	92.0	4.6
		2. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	86.3	4.1
<i>Үнэлгээний дундаж оноо</i>		<i>Хувь 89.2, Оноо 4.5</i>		
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	67.8	3.4
<i>Үнэлгээний дундаж оноо</i>		<i>Хувь 67.8, Оноо 3.4</i>		
4	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1. Засаглалын болон эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	76.4	3.7
		2. Хэрэглэгчийн үнэлгээ	75.4	3.8
<i>Үнэлгээний дундаж оноо</i>		<i>Хувь 75.9, Оноо 3.7</i>		
Ерөнхий үнэлгээ		78.6	4.0	

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 123 дугаар тушаалаар “Дотоод аудитын хороо”-г 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2013 онд 2 удаа хуралдаж, 4 асуудал хэлэлцүүлжээ.

Эрүүл мэндийн салбарын дотоод аудитын үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөө, дотоод аудитын үйл ажиллагааны 2013 оны төлөвлөгөөг боловсруулж, дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн, хорооны тогтоолоор батлуулан ажилласан байна.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 155 дугаар тушаал, Дотоод аудитын хорооны 01 дүгээр тогтоолоор батлагдсан үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу тухайлсан аудитын төлөвлөгөө /удирдамж/-г Эрүүл мэндийн сайдаар батлуулан ажиллажээ.

Дотоод аудитын хорооны 01 тоот тогтоолоор батлагдсан үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний дагуу дараах дотоод аудитыг гүйцэтгэн, Дотоод аудитын хорооны 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2013 оны 155 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэл, зарцуулалт, хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалтын дотоод аудит;
2. Улаанбаатар хотод баригдаж байгаа эмнэлгийн 5 шилжих барилга, Өвөрхангай аймгийн БОЭТ-ийн өртгөлийн барилгын дотоод аудит;
3. Баянхонгор, Өвөрхангай, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2013 оны эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах үйл ажиллагаанд дотоод аудит.

Түүнчлэн Эмгэг судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төвд болон Орхон, Сэлэнгэ аймагт цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, мөнгөн тэтгэмж, бараа материалын нөөц, төсвийн холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хийх дотоод аудитын ажлыг хийж гүйцэтгэн, Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болжээ.

Дээрх байдлаас үзэхэд тус газар Сангийн яамнаас гаргасан дотоод аудитын талаарх журам, заавар, аргачлалын дагуу дотоод аудитыг хэрэгжүүлэх эхлэлийг зохих шаардлагын дагуу тавьсан байна.

### **Эрүүл мэндийн салбарын 2013 онд явуулсан үйл ажиллагааны товч үр дүн**

Эрүүл мэндийн сайдын сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар дараах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тайлант хугацаанд хийсэн ажлын талаарх товч үр дүнг танилцуулж байна. Үүнд:

- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаарх бодлого;
- Эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;
- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоол, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд эрүүл мэндийн талаар нийт 22 бодлогын зорилт, 38 арга хэмжээ туссан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан хууль, тогтоол 3, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн, танилцуулсан асуудал 10, Засгийн газраар батлагдсан тогтоол 7 байна.

Дээрх зорилтын биелэлтийн талаарх ЭМЯ-ны үнэлгээний тайлангаас үзэхэд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дэх Эрүүл мэндийн бодлогын зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт 2013 оны байдлаар дундаж хувь 77.1, үүнээс 8

арга хэмжээний биелэлт 100 хувь, 90-95 хувь-2, 80-85 хувь-7, 7 арга хэмжээ-70 хувь, 7 арга хэмжээ-60-65 хувь, 2 арга хэмжээ-50 хувь, 1 арга хэмжээний биелэлт 40 хувь байна.

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны гол статистик тоон мэдээллийг товчлон дурдвал дараах байдалтай байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлт	2012 он	2013 он	Зөрүү
Төрөлт	6,8327	7,3075	Төрөлт 6.9 хувиар нэмэгдсэн.
Эхийн эндэгдэл	100,000 төрөлтөд 48.1	100,000 төрөлтөд 42.2	Эхийн нас баралт 5.9 промиллээр буурлаа.
Нялхсын эндэгдэл	Амьд төрсөн 1,000 хүүхдэд 15.0	Амьд төрсөн 1,000 хүүхдэд 14.1	Нялхсын эндэгдэл 0.9 промиллээр буурлаа.
5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл	Амьд төрсөн 1,000 хүүхдэд 18.3	Амьд төрсөн 1,000 хүүхдэд 17.5	5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл 0.9 промиллээр буурлаа.
Хүн амын нийт нас баралт	15,523	14,726	Хүн амын нийт нас баралт 5.1 хувиар буурлаа.
Халдварт өвчин	10,000 хүн амд 139,8	10,000 хүн амд 122,5	Халдварт өвчин 17,3 хувиар буурсан байна.
Тэмбүү	10,000 хүн амд 15.7	10,000 хүн амд 19.8	Тэмбүү 4,1 промиллээр өслөө.
Салхин цэцэг	10,000 хүн амд 8.7	10,000 хүн амд 14.8	Өмнөх оноос 1,7 дахин өслөө
Өвчний учир амбулаторит үзүүлсэн өвчтөн	6,056,596	6,366,794	Амбулаторийн үзлэг 310,198 хүнээр нэмэгджээ
Эмнэлэгт хэвтэлт	652,789 хүн	663,259 хүн	Эмнэлэгт хэвтэлт 16 хувиар нэмэгдсэн байна
Шинээр бүртгэгдсэн халдварт бус өвчний тохиолдол	1,024,034	1,213,138	Шинээр бүртгэгдсэн халдварт бус өвчний тохиолдол 18,5 хувиар өслөө

Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт гарсан онцлох үйл явцыг товчлон хураангуйлан тэмдэглэв.

- **Элэг болон Үүдэл эс шилжүүлэн суулгах лаборатори** - ийг Улсын нэгдүгээр төв эмнэлэгт байгуулж, эрхтэн шилжүүлэн суулгахад шаардлагатай шинжилгээг эх орондоо хийж, эрхтэн шилжүүлэх олон ажлын эхлэл тавьжээ.
- **“Удам зүйн лаборатори”**-ийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд нээснээр ургийн гажгийг генийн түвшинд эрт оношлох чадавх бүрджээ.
- **“Перинатологийн төв”**-ийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд байгуулснаар нярайн үеийн оношилгоо, эмчилгээг олон улсын стандартын дагуу үзүүлэх боломжбүрдсэн байна.
- **Улсын гуравдугаар төв эмнэлэг-зүрхний шигдээс**, цус харвалттай өвчтөнд эрчимт эмчилгээ, нөхөн сэргээх цогц тусламжийг цаг алдалгүй үзүүлдэг болжээ.
- **Аймгийн оношилгооны төв**-ийг 11 аймагт, цаашдаа үлдсэн бүх аймгуудад байгуулснаар иргэд ходоод, уушги, бүдүүн гэдэс, урологийн дурангийн иж бүрдэл, компьютер томограф, дижитал ЭХО болон лабораторийн багц шинжилгээ хийж байна.
- Эрүүл мэндийн бодлогын шинэчлэлийн хүрээнд “Тамхины хяналтын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулж, тамхи татахыг хориглосон олон нийтийн газрын

хүрээг өргөжүүлсэн нь иргэдийн дам тамхидалтын хор уршгаас хамгаалах, хүүхэд залуучуудын дунд тамхины хэрэглээг бууруулах чухал ач холбогдолтой арга хэмжээ болжээ.

Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулж, тэдгээрээр төлөөлүүлэн хэрэгжүүлсэн нь санхүүгийн тайлагналын хувьд тайлант хугацаанд хийгдсэн томоохон өөрчлөлтийн нэг болжээ.

Эрүүл мэндийн яам дээрх өөрчлөлтийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын санхүүгийн тайланг орон нутгийн санхүүгийн тайланд шилжүүлэх ажлыг Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу зохион байгуулсан байна.

Сум, өрхийн эмнэлгийн 2012 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл 7,786.0 сая төгрөгийн цэвэр хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайлангийн үзүүлэлт тус бүрээр нэгтгэж шилжүүлсэн байна.

### **Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, түүвэр сорил хийхээр төлөвлөсөн байгууллагын дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

### **Өмнөх түвшинд хийсэн аудитын дүнгийн талаар**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 160 нэгж байгууллага нэгтгэсэн бөгөөд тэдгээрийн 73,75 хувь буюу 118 байгууллагын 7-д Үндэсний аудитын газар, 98-д орон нутаг дахь аудитын байгууллага, 14-д хараат бус аудитын байгууллага санхүүгийн аудит хийж дүгнэлт гаргасан байна.

Аудитад хамрагдсан байгууллагын 83,9 хувь буюу 99 байгууллага зөрчилгүй, 15,3 хувь буюу 18 байгууллага хязгаарлалттай, 1 байгууллага дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт авчээ.

Аудитаар нийт 1,393.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах 20 албан шаардлага, 206,5 сая төгрөгийн 23 төлбөрийн акт тогтоож, аудит хийсэн байгууллагад хариуцуулсан байна.

Аудитын явцад илэрсэн зөрчлийг дуусвар болгосон тайлан, менежментийн захидалд тусгасан байдлаар ангилан нэгтгэхэд дуусвар болгосон тайланд 380 асуудлаар 7,675.6 сая төгрөг, менежментийн захидалд 132 асуудлаар 3,618,08 сая

төгрөгийн зөрчил дутагдлыг аудит хийлгэсэн байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж, баталгаажуулсан байна.

Энэ шатанд хийсэн санхүүгийн аудитаар нийт үйлчлүүлэгч байгууллагын 2013 оны санхүүгийн тайланд 85 асуудлаар 4,167,3 сая төгрөгийн залруулга хийжээ.

Дуусвар болгосон тайланд дурдагдсан нийт зөрчлийн 72,8 хувь нь аймаг, нийслэлд, 27,2 хувь нь Эрүүл мэндийн яамны шууд харъяанд байдаг байгууллагуудад хийсэн аудитаар илэрсэн зөрчил байна.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн аудитын дүнг аудитын явцад санхүүгийн тайланд хийсэн залруулга, төлбөрийн акт, албан шаардлага, дуусвар болгосон тайлан, менежментийн захидалд тусгагдсан зөрчлийг **тоо, мөнгөн дүнгээр**, өмнөх зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг **биелэлт, хувь** гэсэн үзүүлэлтээр, санал дүгнэлтийн хэлбэрийг **тоогоор** тус тус илэрхийлж, нэгтгэн ажлын баримтад хавсаргав.

Нийслэлийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын 28 байгууллага нэгтгэгдэж байгаа бөгөөд нийслэлийн хэмжээнд 1,224.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 16,0 хувийг эзэлж байна. Эдгээр зөрчлийн нэгтгэлийг ажлын баримтад хавсаргав.

Нийслэлийн хэмжээнд гарсан нийт зөрчлийн 17,2 хувь буюу 211,1 сая төгрөг нь мөнгөн хөрөнгөтэй холбоотой, 4,6 хувь буюу 56,1 сая төгрөг нь авлагатай холбоотой, 11,4 хувь буюу 139,3 сая төгрөг нь бараа материалтай холбоотой, 22,8 хувь буюу 279,2 сая төгрөг нь үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал байна.

Аймгийн эрүүл мэндийн байгууллагад хийсэн аудитаар нийт 4,360.73 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэн бөгөөд нийт зөрчлийн 42,9 хувь буюу 1,871,2 сая төгрөг нь Орхон аймагт, 10,8 хувь буюу 469,3 сая төгрөг нь Сэлэнгэ аймагт, 5,1 хувь буюу 224,0 сая төгрөг нь Говь-Алтай аймагт тус тус ногдож байна.

Орхон аймгийн эрүүл мэндийн байгууллагад хийсэн аудитын явцад санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгөнд тайлагнасан 647,5 сая төгрөгийн дуусаагүй барилга бүртгэснийг тодруулахад 2013 оны 7 дугаар сараас улсын комиссын актаар ашиглалтанд хүлээн авсан одоо ЭМГ үйл ажиллагаа явуулж буй барилгыг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна. Ашиглаад хагас жил болсон барилгыг дуусаагүй барилгад бүртгэснээс, ашигласан хугацаандаа элэгдэл тооцогдоогүй байна. Иймд тус барилгыг дуусаагүй барилга данснаас барилга байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэх шийдвэрийг гаргуулж, ашигласан хугацааны элэгдлийг нөхөн байгуулах шаардсан албан шаардлага хүргүүлжээ.

Мөнгөн гүйлгээний тайланд Эрүүл мэндийн яамнаас ирсэн 19,9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт, ХӨСҮТ-с ирсэн 2,62 сая төгрөг, орон нутгаас өгсөн санхүүжилт 12,4 сая төгрөг, Сангийн яамнаас өмнөх оны хэмнэлтийн урамшуулал 311,3 мянган төгрөгийг тус тус төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогод бөөн дүнгээр буруу бүртгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн байгууллагад хийсэн аудитын явцад нягтлан бодогчдын ажлын хариуцлагаас шалтгаалж аймгийн Эрүүл мэндийн газар харилцах дансны 21,6 сая төгрөгийн үлдэгдлийг зардлаар бүртгэснээс үйл ажиллганы цэвэр мөнгөн гүйлгээ буруу илэрхийлэгдсэн байна.



Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 230 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Мандал сумын Нэгдсэн эмнэлэг УБТЗХНН-ын харъяа эмнэлэгтэй нэгдсэн боловч Төмөр замын эмнэлгийн санхүүжилт 236,2 сая төгрөгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын холбогдох заалтыг зөрчсөн байна.

## **Төсвийн ерөнхийлөн захирагчийн шатанд хийсэн аудитын дүнгийн талаар**

### **Асуудал 1: Мөнгөн хөрөнгийн талаар**

Аудитын явцад хийсэн судалгаагаар эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны 5 банкинд нийт 38 харилцах данс байгаа бөгөөд 23 харилцах данс нь зохих зөршөөрөлтэй жижиг мөнгөн сангийн зориулалтаар ашиглагдаж байна. Харин 10 байгууллагын 15 харилцах данс зохих зөвшөөрөлгүй, ашиглалт, зориулалт нь тодорхойгүй ашиглалтгүй байгаа тул дансдыг хаалгаж, 398,1 сая төгрөгийг төрийн сангийн зохих дансанд төвлөрүүлэв.

### **Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар**

Аудитын явцад Эрүүл мэндийн яамны нэр дээр 2013 онд импортоор оруулж ирсэн 3.2 сая ам.доллар буюу 4,472,6 сая төгрөгийн барааг холбогдох байгууллага нь зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгасан эсэхийг тулган баталгаажуулав.

Импортоор орж ирсэн дээрх эм, эмнэлгийн хэрэгслээс Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 4,036,5 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 13 дугаар тушаалаар харьяа зарим байгууллагад хуваарилан нийлүүлсэн байна.

Гэтэл Гэмтэл, согог судлалын үндэсний төв 128,7 сая, Хавдар судлалын үндэсний төв 536,3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Тусламжаар ирсэн тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэл тайланд тусгаагүй нь анхны хуваарьт өөрчлөлт орсон боловч залруулсан шийдвэр гараагүй, анхан шатны баримт өгөөгүйтэй холбоотой байна

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй 665,0 сая төгрөгийн эмнэлэгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг тухайн байгууллагын санхүүгийн тайлан, бүртгэлд зах зээлийн үнээр тусгаж, нэгдсэн тайланд 420,7 сая төгрөгийн залруулга хийлээ.

### **Асуудал 3: Орлогын талаар**

Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийн дүн нэгтгэсэн санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрдөг. Харин хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг доод шатны байгууллагууд дахин орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгадаг нь орлогын давхардал бий болгож байна.

Эрүүл мэндийн салбар тайлант хугацаанд 38,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт авсан бөгөөд энэ хэмжээгээр орлогын давхардлыг аудитын явцад залруулсан болно.



#### **Асуудал 4: Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг байгууллагын жагсаалтыг гаргуулж, санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан эсэхийг тулган баталгаажуулахад Эрүүл мэндийн яамны барилга захиалагчийн алба, Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2013 оны санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд оруулж, тайлагнаагүй байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 54.2-т заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрүүл мэндийн яам Төсвийн тухай хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Оргил рашаан сувилал” ТӨҮГ-ыг өөрийн мэдэлд бүрэн авч, санхүүгийн нэгтгэсэн тайландаа тусгах асуудлыг Засгийн газар, Төрийн өмчийн хороонд тавьсан боловч шийдэгдээгүй байна.

Эрүүл мэндийн яамны барилга захиалагчийн алба болон Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн удирдлагуудыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилсон бөгөөд чиг үүрэг, эрхэлдэг үйл ажиллагаа нь тус яамны чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд энэ салбарын бүрэн хяналтанд багтаж байгаа тул санхүүгийн нэгтгэсэн тайланд тэдгээрийн санхүүгийн тайланд тусгах ёстой гэж үзэж энэ талаар Эрүүл мэндийн яамнаас холбогдох тайлбар, тодруулгыг албан бичгээр гаргуулж авсан болно.

Барилга захиалагчийн алба нь Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолоор татан буугдсан тул тус байгууллагын өмч хөрөнгө, өр авлага, төсвийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, бусад үр дүнг шийдвэрлэж, хаалтын баланс гаргах зэрэг ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх комисс томилон ажиллуулах, Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн хуулийн этгээдийн хэлбэр, цаашдын чиг үүрэг, үйл ажиллагааг нэгтгэсэн тайланд хэрхэн тусгах асуудлыг шийдвэрлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **Асуудал 5: Орон нутаг дахь тусгай шилжүүлгийн талаар**

Эрүүл мэндийн сайд орон нутаг дахь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулж, тэдгээрээр төлөөлүүлэн хэрэгжүүлжээ.

Энэ нь орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилготой бөгөөд гэрээгээр талуудын хооронд үүсэх харилцаа, эрх үүрэг, хүлээх хариуцлага, хүрэх үр дүн, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, түүний гүйцэтгэл, тайлагналд тавигдах шаардлага, үйлчилгээний чанар, стандарт, гэрээ дүгнэх бусад шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, баталгаажуулсан байна.

Эрүүл мэндийн яам Төсвийн тухай хуулийн 39.5-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан дээрх гэрээний хэрэгжилт, үр дүнг

дүгнэж, үнэлгээ өгсөн байна. Тус яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хийсэн энэ үнэлгээгээр аймаг, нийслэлийн Засаг дарга нар гэрээгээр хүлээсэн үүрэг болох орон нутаг дахь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хангалтгүй хэрэгжүүлсэн дүнтэй гарсан байна.

Тухайлбал Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн ерөнхий үнэлгээг хувиар тооцвол гэрээний биелэлт дундажаар 48,2 хувьтай гарсан бөгөөд гэрээ байгуулсан аймаг, нийслэлийн 50 хувь нь 38,2 хувиас доогуур үнэлгээ авсан байна. Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийн дүнг ажлын баримтанд хавсаргав.

Зарим аймаг гэрээний биелэлтийг Эрүүл мэндийн яаманд ирүүлэхдээ тайлан мэдээг буруу, дутуу гаргах, огт ирүүлэхгүй байх зэргээр гэрээний үүргээ бүрэн ухамрсарлаагүй, хариуцлагагүй хандсан талаар үнэлгээний танилцуулгад онцлон тэмдэглэжээ.

Гэтэл Эрүүл мэндийн яам дээрх гэрээний хэрэгжилт, үр дүнг харгалзан үзэлгүй 2013 онд гэрээний дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан баталсан 85,1 тэрбум төгрөгийг орон нутагт төлөвлөсөн хэмжээгээр 100 хувь санхүүжүүлсэн байна.

Төв, орон нутгийн байгууллагуудын ажлын уялдаагүй, зохион байгуулалтгүй, урсгалаараа, хариуцлагагүй энэ байдал нь гэрээний ач холбогдол, үнэ цэнийг бууруулаад зогсохгүй орон нутаг дахь анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ зохих шаардлагын хэмжээнд ард иргэдэд хүрч чадахгүй байх үндсэн шалтгааны нэг болж байна.

Эрүүл мэндийн сайдад гэрээг зохион байгуулалттай, үр дүнтэй хэрэгжүүлэх замаар орон нутаг дахь анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид бодитой ахиц дэвшил гаргахын тулд гэрээний зорилго, ач холбогдол, үнэ цэнийг талуудад харилцан ойлгуулах тодорхой ажил зохион байгуулж, гэрээнд заасан хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгож, үр дүнг бодитой тооцож, холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **Асуудал 6: Худалдан авах ажиллагааны талаар**

Төлөвлөсөн ёсоор салбарын хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг Сангийн яаманд хүргүүлсэн тайлантай тулган баталгаажуулж, худалдан авах ажиллагааг иж бүрэн, бодитой төлөвлөж, тайлагнасан эсэхийг тулган баталгаажуулав.

Эрүүл мэндийн яам худалдан авах төлөвлөгөө, тайланг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад үндэслэн гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн төлөвлөж, тайлагнаагүйг харуулж байна.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсөв, өөрийн хөрөнгө, зээл,

тусламжийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, иж бүрэн төлөвлөж, тайлагнах ёстой.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын түвшин тус бүрийг шат шатанд нь нэгтгэх замаар салбарын хэмжээний худалдан авах ажиллагааг нэгтгэж, удирдах боломж бий болгох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### **Асуудал 7: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Эрүүл мэндийн салбар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-т заасан *“Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалтын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулан салбарын хэмжээнд санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Гэвч 2010 онд баталсан тус баримт бичгийг санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, шинээр батлагдсан Төсвийн тухай хууль, тогтоомж зэрэг стандарт, эрх зүйн орчны шинэчлэл, бодлогын өөрчлөлтэй уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлог, эрх зүйн орчинтой нийцүүлэн боловсруулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд стандартын дагуу үнэн зөв тусгах, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг батлагдсан хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зөв ангилж бүртгэх, тайлагнах, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах зэрэг үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, стандартын хүрээнд явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм. Энэ асуудлыг холбогдох хүмүүстэй зөвшилцөж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Эдгээр асуудал болон санхүүгийн дотоод хяналтын талаархи бидний үнэлэлт дүгнэлт, менежментийн захидалтай нийлээд аудитаар илрүүлсэн гол зүйлсийг бүрдүүлж өгнө.

### **Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 94,711.7 сая, нийт зарлага 463,890.1 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд 85,423.1 сая төгрөгийн орлогыг нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлогоос, 9,288.7 сая төгрөгийн орлогыг харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Харин нийт зардлагын 86,6 хувь буюу 401,621.2 сая төгрөгийг урсгал зардал, 18,3 хувь буюу 85,094.1 сая төгрөгийг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тусгай зориулалтын шилжүүлэг, 8,8 хувь буюу 40,815.5 сая төгрөгийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд тайлант хугацаанд 416,1 тэрбум зарцуулж, батлагдсан төсвийг 11,3 хувь буюу 47,7 тэрбум төгрөгөөр хэмнэжээ. Харин урсгал төсвийн 97,8 хувь буюу 394,0 тэрбумтөгрөгийг зарцуулж, 8.9 тэрбум төгрөгөөр хэмнэсэн байна.

Урсгал зардлын дээрх хэмнэлт нь цалинтай холбоотой зардал 2.2 тэрбум, тогтмол зардал 1.9 тэрбум, төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1.4 тэрбум, мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал 1.5 тэрбум, бусад зардал 1.9 тэрбум төгрөг зарцуулаагүйтэй холбоотой байна. Үүнд төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүй хийсэн, төлөвлөсөн ажлыг тайлант хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын тайланд нэгтгэсэн бөгөөд төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу Эрүүл мэндийн яамнаас албан ёсоор гаргуулж, баталгаажуулан ажлын баримтад хавсаргав.

### **Залруулаагүй алдаа**

Аудитын олон улсын стандартын дагуу аудитын явцад илрүүлсэн санхүүгийн тайланд залруулаагүй материаллаг биш аливаа алдаа, зөрчлийг тухайн байгууллагын удирдлагын анхааралд хандуулах шаардлагатай байдаг.

Дээрх шаардлагын дагуу энэ удаагийн аудитаар илэрсэн зарим алдаа зөрчлийг арилгах, цаашид дахин давтан гаргахгүй байхыг аудитын явцад үүрэг болгож, асуудлын бүртгэлд 7 асуудал тусгасанаас Эрүүл мэндийн яамны удирдлагад 6 асуудлын мөрөөр холбогдох арга хэмжээ авах зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийг тусгайлан Менежементийн захидалд тусгасан болно.

Аудитаар нийт 8,738.7 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч, 59,9 хувь буюу 5,230.4 сая төгрөгийн зөрчил дутагдлыг аудитын явцад залруулж, 40,1 хувь буюу 3,508.3 сая төгрөгийн зөрчил, дутагдлыг залруулаагүй байна. Залруулаагүй алдаа, зөрчлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргав.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2012 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 6 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжид нягтлан бодогч болон удирдах ажилтнуудын ажлын үр дүнг санхүүгийн тайлан гаргалт, аудитын дүгнэлттэй уялдуулан дүгнэж байх, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгуулах, хөрөнгийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах, хууль зөрчсөн албан тушаалтнуудад арга хэмжээ тооцож байх зэрэг асуудал багтсан байна.

Эрүүл мэндийн яам нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэх, дотоод хяналтыг сайжруулах зэрэг зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээ авч тодорхой үр дүнд хүрсэн байна. Харин худалдан авах ажиллагаа, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг зохих журмын дагуу бүртгэж тайлагнах, гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөр, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн

хөрөнгүүдийг данс бүртгэлд тусгах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өмнөх шатанд хийсэн аудитын дүнгээс үзэхэд эрүүл мэндийн салбарын байгууллагад 2012 онд 108 зөвлөмж өгснөөс 84 зөвлөмж хэрэгжиж, биелэлт 77.77 хувьтай байна.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2013 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор өмнөх шатанд хийсэн аудитын дүнг үнэлж, нэгтгэх, аудит хийгдээгүй зарим байгууллагын харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлтүүдтэй тулган шалгав.

Салбарын хэмжээний 2013 оны төсвийн гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгож, аудитын явцад тооцсон эрсдэлийг харгалзаж материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 1 хувиар тооцсон бөгөөд нийт зөрчил нь материаллаг байдлын түвшингээс доогуур байна.

Иймээс бидний дүгнэлтээр Эрүүл мэндийн яамны бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь бүгд материаллаг зүйлсийн хувьд 2013 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.





**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Н.УДВАЛ  
ТАНАА

2014.04.25 № 670

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Эрүүл мэндийн яамны удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайланг хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрүүл мэндийн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД





## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

### Менежментийн захидал

Агуулга

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1

**Санхүүгийн тайлангийн нэгтгэлийн талаар**

Асуудал 2

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт  
бичгийг боловсронгуй болгох талаар**

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 3

**Орон нутаг дахь тусгай шилжүүлгийн талаар**

Асуудал 4

**Худалдан авах ажиллагааны талаар**

Асуудал 5

**Олон улсын байгууллагаас ирүүлсэн зээл,  
тусламжийн хөрөнгөнд тавих хяналтын талаар**

Асуудал 6

**Хариуцлага тооцох тухай**

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн түвшинд хийсэн санхүүгийн аудитаар үйлчлүүлэгч байгууллагад хандаж, 122 зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа бөгөөд Эрүүл мэндийн яамны удирдлагад хандсан болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтсийн ажилтнууд болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.**

### **Ажиглалт**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг байгууллагын жагсаалтыг гаргуулж, санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгасан эсэхийг тулган баталгаажуулахад Эрүүл мэндийн яамны барилга захиалагчийн алба, Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн 2013 оны санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд оруулж, тайлагнаагүй байна.

Эдгээр байгууллагын удирдлагыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар томилсон бөгөөд чиг үүрэг, эрхэлдэг үйл ажиллагаа нь тус яамны чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд энэ салбарын бүрэн хяналтанд багтаж байгаа тул санхүүгийн нэгтгэсэн тайланд тэдгээрийн санхүүгийн тайланд тусгах ёстой гэж үзэж энэ талаар Эрүүл мэндийн яамнаас холбогдох тайлбар, тодруулгыг албан бичгээр гаргуулж авсан болно.

### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай иж бүрэн байх, толилуулга ба илчлэлийн талаархи батламж мэдэгдэл зөрчигдөх эрсдэл байна.

### **Зөвлөмж**

Барилга захиалагчийн алба Засгийн газрын 2014 оны 93 дугаар тогтоолоор татан буугдсан тул тус байгууллагын өмч хөрөнгө, өр төлбөр, авлага, төсвийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, бусад үр дүнг шийдвэрлэж, хаалтын баланс гаргах зэрэг ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх ажлын хэсэг томилон ажиллуулах

“Оргил рашаан сувилал” ТӨҮГ болон Монгол Солонгосын Дорнын анагаах ухааны төвийн хуулийн этгээдийн хэлбэр, цаашдын чиг үүрэг, үйл ажиллагааг нэгтгэсэн тайланд хэрхэн тусгах асуудлыг шийдвэрлэх

Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх

### **Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

### **Ажиглалт**

Эрүүл мэндийн салбар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-т заасан “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалтын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулан салбарын хэмжээнд санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Гэвч 2010 онд баталсан тус баримт бичгийг санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, шинээр батлагдсан Төсвийн тухай хууль, тогтоомж зэрэг стандарт, эрх зүйн орчны шинэчлэл, бодлогын өөрчлөлтэй уялдуулан боловсронгуй болгох шаардлагатай байна.

### **Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого тодорхойгүй байснаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд буруу тусгах,

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг буруу ангилж бүртгэх

Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг тухай бүр хангаж ажиллахгүй зөрчил дутагдал гаргах

Эдгээрээс гадна санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай батламж мэдэгдэлүүд зөрчигдөх эрсдэлтэй юм.

### **Зөвлөмж**

Одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, шинээр батлагдсан Төсвийн тухай хууль, тогтоомж зэрэг стандарт, эрх зүйн орчны шинэчлэл, бодлогын өөрчлөлтэй уялдуулан боловсронгуй болгож, 2014 оны эхний хагас жилд багтаан баталгаажуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2014 онд багтааж, Үндэсний аудитын газарт ирүүлэх

### **Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

### **Ажиглалт**

Эрүүл мэндийн сайд орон нутаг дахь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга нартай гэрээ байгуулж, тэдгээрээр төлөөлүүлэн хэрэгжүүлжээ.

Эрүүл мэндийн яам дээрх гэрээний хэрэгжилт, үр дүнг харгалзан үзэлгүй 2013 онд гэрээний дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зориулан баталсан 85,1 тэрбум төгрөгийг орон нутагт төлөвлөсөн хэмжээгээр 100 хувь санхүүжүүлсэн байна.

### **Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай үнэн зөв байх, тохиолдсон байх Хэмжилт ба толилуулгын талаар батламж мэдэгдэлүүд зөрчигдөх эрсдэлтэй байна.

### **Зөвлөмж**

Засаг дарга нартай байгуулсан гэрээг зохион байгуулалттай, үр дүнтэй хэрэгжүүлэх замаар орон нутаг дахь анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид бодитой ахиц дэвшил гаргахын тулд гэрээний зорилго, ач холбогдол, үнэ цэнийг талуудад харилцан ойлгуулах тодорхой ажил зохион байгуулж, гэрээнд заасан хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгож, үр дүнг бодитой тооцож, холбогдох арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2014 онд багтааж, Үндэсний аудитын газарт ирүүлэх

### **Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

**Ажиглалт**

Эрүүл мэндийн яам худалдан авах төлөвлөгөө, тайланг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад үндэслэн гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн төлөвлөж, тайлагнаагүйг харуулж байна.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсөв, өөрийн хөрөнгө, зээл, тусламжийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, иж бүрэн төлөвлөж, тайлагнах ёстой.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай үнэн зөв байх, тохиолдсон байх Хэмжилт ба толилуулгын талаар батламж мэдэгдэлүүд зөрчигдөх эрсдэлтэй байна.

**Зөвлөмж**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын түвшин тус бүрийг шат шатанд нь нэгтгэх замаар салбарын хэмжээний худалдан авах ажиллагааг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр нь нэгтгэж, удирдах тогтолцоо бий болгох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2014 онд багтааж, Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.



### **Ажиглалт**

Аудитын явцад Эрүүл мэндийн яамны нэр дээр 2013 онд импортоор оруулж ирсэн 3.2 сая ам.доллар буюу 4,472,6 сая төгрөгийн барааг холбогдох байгууллага нь зохих журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгасан эсэхийг тулган баталгаажуулав.

Импортоор орж ирсэн дээрх эм, эмнэлгийн хэрэгслээс Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд 4,036,5 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 13 дугаар тушаалаар харъяа зарим байгууллагад хуваарилан нийлүүлсэн байна.

